

Цэцэрлэг элсэлт авч байна



Ковид19-ийн нөхцөл байдлаас болоод **элсэлт хүүхдүүдийн оролцоогүйгээр** явагдах бөгөөд мөн боломжтой бол хууль ёсны асран хамгаалагч (эцэг эх) нартай уулзахгүйгээр явагдана.

Цэцэрлэгт 2-6 насны хүүхдүүд явж болно.

- 3 настай (2018 оны 9-р сарын 1-нээс өмнө төрсөн) хүүхдүүд цэцэрлэгт орох эрхтэй учир, давуу эрхийн дагуу 2 настай хүүхдүүдээс өмнө цэцэрлэгт түрүүлж орох боломжтой, яагаад гурваас доош насны хүүхдүүд цэцэрлэгт орж болох боловч хуулийн дагуу эрхгүй юм.

2021/2022 оны хичээлийн жилийн сургуулийн өмнөх боловсрол нь дараах хүүхдүүдэд заавар хамрагдах ёстой:

- 2015 оны 9-р сарын 1-нээс – 2016 оны 8-р сарын 31-нд төрсөн хүүхдүүд
- сургуульд явах хугацааг хойшлуулсан бол (2014 оны 9-р сарын 1-нээс – 2015 оны 2-р сарын 31-нд төрсөн) – цэцэрлэгт явах эсвэл бэлтгэл ангид явах ёстой.

Гуравдагч орны иргэд, эцэг эхчүүд хүүхдээ цэцэрлэгт ороход оройтлоо гэхэд цэцэрлэгт орохын өмнөх өдөр хууль ёсны дагуу Чех улсад оршин сууж байгаа болохыг нотлох ёстой (Чех улсад 90 хоногоос дээш хугацаагаар байнга эсвэл түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл). Сургуулийн өмнөх боловсролд хүүхдийн оршин суух зөвшөөрөл шаардагдахгүй.

Огноо:

2021 оны 5-р сарын 2-ноос 16-г хүртэл

Элсэлт өгөх тодорхой он сарыг өөрийн сонгосон цэцэрлэгийн цахим хуудаснаас олж мэдэх боломжтой.

Усти над Лабем хотод цахим бүртгэл 4-р сарын 1-нээс 5-р сарын 13 хүртэл дараах холбоосоор авч байгаа <https://zapisms.usti-nad-labem.cz>.

Элсэлтийн явц байдал:

1. Хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд элсүүлэх өргөдлийг бөглөх (өргөдөл).

- Өргөдлийг бөглөхдөө
- цахимаар (зөвхөн зарим цэцэрлэгт)
 - цэцэрлэгийн цахим хуудаснаас татаж авж болно
 - цэцэрлэгээс авж болно (өмнө цаг тохирвол сайн)

2. Бөглөсөн өргөдөл дээрээ хууль ёсны асран хамгаалагч (эцэг эх) хоёулаа гарын үсэг зурсан байх ёстой.

Хэрэгтэй бичиг баримтууд:

Бүртгэлд хэрэгтэй бичиг баримтуудыг элсэлт өгөх цэцэрлэгийн цахим хуудаснаас аван боломжтой.

Сургуулиуд ихэвчлэн дараах баримтуудыг шаарддаг:

- оршин суух зөвшөөрөл эсвэл паспорт
- төрсний гэрчилгээ
- **Эмчийн бичиг** - хүүхэд тогтмол вакцин хийлгэсэн, эсвэл вакцин хийлгэх боломжгүй гэсэн эмчийн баталгаажуулсан бичиг, эсвэл хүүхдийг албадан вакцинжуулах тухай мэдэгдэл, хүүхдийн Чехийн вакцинжуулалтын картын хуулбар (сургуулийн өмнөх боловсролыг хамрагдах хүүхдүүдэд хамааралгүй)
- хэрвээ сургуулийн зөвлөгөө өгөх газар хандсан бол зөвлөмжийн хуулбар

Та бичиг баримтуудаа алсаас баримтжуулж боломжтой, ердөө л энгийн хуулбар эсвэл скан хийж явуулах боломжтой.

Өргөдөл өгөх:

Өргөдлийг дараах байдлаар бүрдүүлж явуулж болно:

1. сургуулийн мэдээллийн хайрцагт (сургууль бүр өөрийн гэсэн мэдээллийн хайрцагтай),
2. цахим хаягаар хүлээн зөвшөөрсөн гарын үсэгтэйгээ (энгийн цахим зурвас илгээх боломжгүй),
3. шуудангаар,
4. биеэрээ өгөх (олон хүн цугларуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахын тулд өмнө цаг тохирч уулзалт зохион байгуулахыг санал болгож байна).

Хүүхдийг цэцэрлэгт авах шалгуур:

Захирлууд элсэлтийн шалгуурыг дагаж мөрддөг бөгөөд энэ нь сургуулийн цахим хуудас дээр нийтлэгдсэн байна. Хүүхдийн гэрийн хаяг цэцэрлэгт харьяалалтай ёстой байх, хэдэн настай байх нь, хүүхэд өдөржингөө цэцэрлэгт хамрагдах уу, ах дүүгийн аль нэг нь тухайн цэцэрлэгт явж байгаа гэх мэт дүрмүүд шалгуурт байна.

Эцэг эхчүүд цэцэрлэгээ сонгох эрхтэй бөгөөд сонголтод жишээ нь дугуйлан, сурган хүмүүжүүлэх чиглэл болон бусад зүйлс нөлөөлж болно. Та тогтсон шалгуурыг хараад

элсэлтийн үйл явцад таны хүүхдийг хүлээн авах эсэхийг мэдэх боломжтой. Та элсэлтийн маягтаа олон цэцэрлэгт явуулж болно.

Улсын цэцэрлэгүүдээс гадна хувийн эсвэл сүмийн цэцэрлэгүүд байдаг

Мэдээлэл олгох цахим уулзалт

- элсэлтийн тухай мэдээлэл
- Чехийн цэцэрлэгийн боловсрол болон хүмүүжил
- сургуулийн өмнөх боловсрол
- хүүхдүүдэд зориулсан үйл ажиллагаа болон чех хэл сурах зөвлөмжүүд

Огноо:

2021 оны 4-р сарын 21-ны 14:00 - 16:00 цагийн хооронд – сэдэв: Усти аймгийн цэцэрлэгийн элсэлтийн тухай



– монгол хэлний орчуулагчтай

[Энд](#) бүртгүүлнэ үү.

2021 оны 4-р сарын 27-ны 16:00 - 18:00 цагийн хооронд – сэдэв: Усти аймгийн цэцэрлэгийн элсэлтийн тухай



– орос хэлний орчуулагчтай

[Энд](#) бүртгүүлнэ үү.

2021 оны 4-р сарын 29-ны 16:30 – 18:30 цагийн хооронд – сэдэв: Усти аймгийн цэцэрлэгийн элсэлтийн тухай



– вьетнам хэлний орчуулагчтай

[Энд](#) бүртгүүлнэ үү.



FINANCOVÁNO
EVROPSKOU UNÍÍ
AZYLOVÝ, MIGRAČNÍ
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/28/02 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.